



I-VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 239.7 (49.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний хагас жилд 723.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 239.7 (49.6) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардал 1052.2 тэрбум төгрөг болж, 537.7 (2.0 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2021 I-VI	2022 I-VI	<u>2022 I-VI</u> 2021 I-IV
	сая төгрөг		хувь
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	483 658.9	723 322.9	149.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого	182 981.5	234 305.0	128.0
Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн шимтгэл	8 134.6	14 932.6	183.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	5 817.0	11 368.1	195.4
Малчин	1 812.3	2 761.4	152.4
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	505.3	803.1	158.9
Бусад даатгуулагч	-	-	-
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	174 846.9	219 372.4	125.5
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	42 017.2	81 853.0	194.8
Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө	248 232.6	405 319.4	163.3
Бусад орлого	10 427.6	1 845.5	17.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал	514 487.8	1 052 160.0	2.0¹
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	479 003.2	984 488.5	2.0 ¹
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	2 786.3	15 181.3	5.4 ¹
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	32 698.3	52 490.2	160.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

¹ Дахин их

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нэмэгдэхэд төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл 81.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 39.8 (94.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын хэмжээнд 2022 оны 6 дугаар сард эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 3.5 сая хүн даатгуулсан нь өмнөх оны мөн үеэс 191.4 (5.9%) мянгаар нэмэгджээ. Энэхүү өсөлтөд шимтгэлийг нь ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд 70.5 (8.5%) мянгаар,

шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд өмнөх оноос 24.6 (1.1%) мянгаар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 VI	2022 VI	<u>2022 VI</u> 2021 VI
	хүн		хувь
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид	3 272 200	3 463 630	105.9
Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд	826 246	896 755	108.5
Төсөвт байгууллагын ажилтан	254 046	263 542	103.7
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	572 200	633 213	110.7
Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд	137 677	233 985	170.0
Малчин	39 043	52 340	134.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	88 369	167 934	190.0
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	10 139	13 563	133.8
Бусад даатгуулагч	126	148	117.5
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд	2 308 277	2 332 890	101.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Тайлбар: Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид давхардсан тоогоор орсон.

Ойлголт, тодорхойлолт

Эрүүл мэндийн даатгал: Төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.

Даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ.

Бусад даатгуулагч: Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.9-т зааснаас бусад даатгуулагчид орно.

Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэд: 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж буй ялтныг хамруулж ойлгоно.

Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-т заасан тэтгэвэр авагчид, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-т заасан иргэдийг хэлнэ.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн: Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 -д заасан ҮСХ, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



Эх үүсвэр:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сарын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 8 дугаар сарын 17

Нийгмийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын
Нийгмийн статистикийн хэлтсийн статистикч
Э.Ариунчимэг
Утас : (976-51)-263966

